

АПУ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 26/02

Улаанбаатар хот

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, АПУ ХК (цаашид "Компани" гэх)-ийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх заалт, Компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн 2025 оны хоёрдугаар хагас жилийн санхүүгийн үр дүнг харгалзан хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд 65 (жаран тав) төгрөг, нийт 69,171,800,945 (жаран есөн тэрбум нэг зуун далан нэгэн сая найман зуун мянга есөн зуун дөчин тав) төгрөгийн ногдол ашиг хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоож, ногдол ашгийг 2026 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн дотор төлөхөөр тогтоосугай.
3. Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг хуваарилах ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэгт даалгасугай.

№	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	П.Батсайхан			
2	Б.Батбаяр			
3	Кеннет Чу			
4	Сэн И-Ин			
5	Б.Гантиг			
6	Б.Гомбо-Эрдэнэ			
7	Б.Гэрэлчулуун			
8	О.Одбаяр			
9	Ж.Үнэнбат			